

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/260-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Baasansurens@audit.gov.mn">Baasansurens@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	18-21
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18-19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II бар  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.14 № ДАА-2023/260-НА-ТА-ТДБ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.3 хувьтай тайлагнагдсан байна.

Хангамж, бараа материалын зардлыг 22.4 хувиар, бараа үйлчилгээний бусад зардлыг 6.0 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 4.9 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт зардлыг 0.7 хувиар хэмнэсэн байна.

### Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 91.9 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой

тогтмол зардалд 11,054.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 15,959.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 24,130.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 2,839.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>82,497,801.40</b>	<b>103,703,136.90</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	0	185,999.70
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0</b>	<b>19,800,000.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0</b>	<b>19,800,000.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	19,800,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>82,497,801.40</b>	<b>83,717,137.20</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>27,526,176.40</b>	<b>38,924,607.20</b>
35110	Тусгай зориулалттай материал	27,526,176.40	38,924,607.20
35300	Бэлэн бүтээгдэхүүн	595,080.00	6,107,885.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>54,321,045.00</b>	<b>38,629,145.00</b>
35410	Бичиг хэргийн материал	3,926,820.00	2,926,020.00
35420	Аж ахуйн материал	31,411,725.00	24,911,725.00
35430	Сэлбэг хэрэгсэл	539,000.00	294,000.00
35450	Барилгын засварын материал	194,000.00	42,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,249,500.00	10,455,400.00
35500	Биологийн хөрөнгө	55,500.00	55,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>245,251,489.81</b>	<b>219,520,246.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>245,251,489.81</b>	<b>219,520,246.61</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>240,931,489.81</b>	<b>215,200,246.61</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,400,000.00	29,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,308,333.29	-10,208,333.25
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	339,109,879.61	368,500,879.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	-124,072,086.34	-172,990,401.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,174,411.50	21,174,411.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,372,381.67	-20,676,309.59
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,320,000.00</b>	<b>4,320,000.00</b>
39301	Программ хангамж	7,043,200.00	7,043,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,043,200.00	-7,043,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,320,000.00	4,320,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>327,749,291.21</b>	<b>323,223,383.51</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	0	185,999.70
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>327,749,291.21</b>	<b>323,037,383.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>327,749,291.21</b>	<b>323,037,383.81</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,320,000.00	4,320,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	4,320,000.00	4,320,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>323,429,291.21</b>	<b>318,717,383.81</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	117,425,177.12	323,429,291.21
51220	Тайлант үеийн үр дүн	206,004,114.09	-4,711,907.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>327,749,291.21</b>	<b>323,223,383.51</b>

/ төгрөгөөр /

13998

436


## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,005,946,757.49</b>	<b>751,992,640.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>270,144,657.49</b>	<b>50,754,740.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>270,144,657.49</b>	<b>50,754,740.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>197,175,550.00</b>	<b>0</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	197,175,550.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,035,212.49	29,391,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	71,933,895.00	21,363,740.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>735,802,100.00</b>	<b>701,237,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>680,294,900.00</b>	<b>688,976,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	680,294,900.00	688,976,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,507,200.00</b>	<b>12,261,500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,507,200.00	12,261,500.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>798,265,643.40</b>	<b>750,204,547.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>798,265,643.40</b>	<b>750,204,547.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>797,376,343.40</b>	<b>743,763,455.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>569,906,700.00</b>	<b>553,473,958.63</b>
210101	Үндсэн цалин	447,392,620.90	449,950,895.29
210102	Нэмэгдэл	110,902,379.10	91,380,523.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,611,700.00	12,142,540.09
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,884,400.00</b>	<b>74,205,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	59,005,200.00	50,459,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,969,800.00	5,936,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,975,800.00	4,749,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	994,000.00	1,187,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,939,600.00	11,872,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,821,000.00</b>	<b>11,054,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,882,900.00	2,273,300.00
210302	Түлш, халаалт	7,702,100.00	7,092,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,236,000.00	1,510,800.00
210304	Байрны түрээс	0	178,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,491,275.00</b>	<b>18,219,299.00</b>
210401	Бичиг хэрэг	5,322,200.00	9,213,091.00
210402	Тээвэр, шатахуун	2,065,500.00	4,308,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,672,000.00	2,273,739.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,476,280.00	2,424,469.00
210408	Бараа материал акталсны зардал	955,295.00	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,190,500.00</b>	<b>12,315,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	818,900.00	284,400.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,318,600.00	8,475,200.00
210604	Урсгал засвар	53,000.00	3,556,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>305,000.00</b>	<b>0</b>
210702	Дотоод албан томилолт	305,000.00	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,790,447.15</b>	<b>6,886,654.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	690,000.00	2,168,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	31,500.00	82,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	500,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,957,847.15	4,046,804.20
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>84,987,021.25</b>	<b>67,607,343.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,507,200.00	11,613,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,144,000.00	871,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,335,821.25	55,122,243.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>889,300.00</b>	<b>6,441,092.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>422,400.00</b>	<b>1,315,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	422,400.00	1,315,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>466,900.00</b>	<b>5,126,092.37</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	466,900.00	5,126,092.37
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>207,681,114.09</b>	<b>1,788,092.60</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,677,000.00</b>	<b>6,500,000.00</b>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,677,000.00	6,500,000.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>206,004,114.09</b>	<b>-4,711,907.40</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,141,078,508.54</b>	<b>992,235,373.23</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>405,276,408.54</b>	<b>290,997,473.23</b>
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>405,276,408.54</b>	<b>290,997,473.23</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>405,276,408.54</b>	<b>290,997,473.23</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	405,276,408.54	290,997,473.23
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>735,802,100.00</b>	<b>701,237,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>680,294,900.00</b>	<b>688,976,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	680,294,900.00	688,976,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,507,200.00</b>	<b>12,261,500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,507,200.00	12,261,500.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,141,078,508.54</b>	<b>992,049,373.53</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,141,078,508.54</b>	<b>992,049,373.53</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>734,912,800.00</b>	<b>694,796,807.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>569,906,700.00</b>	<b>553,473,958.63</b>
210101	Үндсэн цалин	447,392,620.90	449,950,895.29
210102	Нэмэгдэл	110,902,379.10	91,380,523.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,611,700.00	12,142,540.09
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,884,400.00</b>	<b>74,205,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	59,005,200.00	50,459,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,969,800.00	5,936,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,975,800.00	4,749,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	994,000.00	1,187,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,939,600.00	11,872,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,821,000.00</b>	<b>11,054,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,882,900.00	2,273,300.00
210302	Түлш, халаалт	7,702,100.00	7,092,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,236,000.00	1,510,800.00
210304	Байрны түрээс	0	178,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,761,500.00</b>	<b>15,959,199.00</b>
210401	Бичиг хэрэг	5,967,000.00	7,886,591.00
210402	Тээвэр, шатахуун	2,065,500.00	3,660,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,672,000.00	2,273,739.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,057,000.00	2,138,869.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,750,400.00</b>	<b>24,130,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	725,400.00	20,061,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	556,000.00	887,000.00
210604	Урсгал засвар	469,000.00	3,182,200.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>305,000.00</b>	<b>0</b>

210702	Дотоод албан томилолт	305,000.00	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>832,600.00</b>	<b>2,839,850.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	690,000.00	2,168,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	31,500.00	82,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56,651,200.00</b>	<b>13,133,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,507,200.00	12,261,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,144,000.00	871,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>406,165,708.54</b>	<b>297,252,565.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>422,400.00</b>	<b>1,315,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	422,400.00	1,315,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>405,743,308.54</b>	<b>295,937,565.90</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	466,900.00	5,126,092.37
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	405,276,408.54	290,811,473.53
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>185,999.70</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	4,320,000.00	0	117,425,177.12	121,745,177.12
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,320,000.00	0	117,425,177.12	121,745,177.12
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	206,004,114.09	206,004,114.09
10	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	4,320,000.00	0	323,429,291.21	327,749,291.21
11	2022 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл	4,320,000.00	0	323,429,291.21	327,749,291.21
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,320,000.00	0	323,429,291.21	327,749,291.21
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-4,711,907.40	-4,711,907.40
20	2022 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	4,320,000.00	0	318,717,383.81	323,037,383.81



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>688,976,400.00</b>	<b>683,850,307.63</b>	<b>5,126,092.37</b>	<b>99.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>688,976,400.00</b>	<b>683,850,307.63</b>	<b>5,126,092.37</b>	<b>99.3</b>
210	Бараа, үйлчилгээний зардал	687,660,800.00	682,535,307.63	5,125,492.37	99.3
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>553,644,000.00</b>	<b>553,473,958.63</b>	<b>170,041.37</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	458,428,600.00	449,950,895.29	8,477,704.71	98.2
210102	Нэмэгдэл	83,071,400.00	91,380,523.25	(8,309,123.25)	110.0
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	12,144,000.00	12,142,540.09	1,459.91	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,205,500.00</b>	<b>74,205,500.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,459,700.00	50,459,700.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,936,400.00	5,936,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	4,749,200.00	4,749,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,187,300.00	1,187,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,872,900.00	11,872,900.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,054,900.00</b>	<b>11,054,900.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл цахилгаан	2,273,300.00	2,273,300.00	-	100.0
210302	Түлш, халаалт	7,092,000.00	7,092,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,510,800.00	1,510,800.00	-	100.0
210304	Байрны түрээс	178,800.00	178,800.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,561,800.00</b>	<b>15,959,199.00</b>	<b>4,602,601.00</b>	<b>77.6</b>
210401	Бичиг хэрэг	10,048,600.00	7,886,591.00	2,162,009.00	78.5
210402	Тээвэр (шатахуун)	3,660,400.00	3,660,000.00	400.00	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,946,000.00	2,273,739.00	672,261.00	77.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,700.00	-	50,700.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,856,100.00	2,138,869.00	1,717,231.00	55.5
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>24,281,700.00</b>	<b>24,130,300.00</b>	<b>151,400.00</b>	<b>99.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,104,500.00	20,061,100.00	43,400.00	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	992,600.00	887,000.00	105,600.00	89.4
210604	Урсгал засвар	3,184,600.00	3,182,200.00	2,400.00	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>2,985,800.00</b>	<b>2,839,850.00</b>	<b>145,950.00</b>	<b>95.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,244,900.00	2,168,000.00	76,900.00	96.6
210803	Даатгалын үйлчилгээ	100,800.00	89,100.00	11,700.00	88.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.00	82,750.00	18,050.00	82.1
210806	Мэдээллийн технологийн зардал	539,300.00	500,000.00	39,300.00	92.7
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>927,100.00</b>	<b>871,600.00</b>	<b>55,500.00</b>	<b>94.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	927,100.00	871,600.00	55,500.00	94.0
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,315,600.00</b>	<b>1,315,000.00</b>	<b>600.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,315,600.00</b>	<b>1,315,000.00</b>	<b>600.00</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,315,600.00	1,315,000.00	600.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>688,976,400.00</b>	<b>683,850,307.63</b>	<b>5,126,092.37</b>	<b>99.3</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>688,976,400.00</b>	<b>683,850,307.63</b>	<b>5,126,092.37</b>	<b>99.3</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	688,976,400.00	683,850,307.63	5,126,092.37	99.3

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	(0.00)	АТММ	0.00	УСМ
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	(0.00)	УСМ	0.00	УСМ
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	УСМ	-	УСМ
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	48.00	48.00		-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	38.00		-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00		-	100.0
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00		-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан


/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		11,162,410.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		11,162,410.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>11,162,410.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>7,104,400.00</b>
210104	Урамшуулал		7,104,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>705,010.00</b>
210401	Бичиг хэрэг		57,010.00
210402	Тээвэр, шатахуун		648,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>175,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		175,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>1,062,000.00</b>
210702	Дотоод албан томилолт		1,062,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>2,116,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,116,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>12,261,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>12,261,500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		11,162,410.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /цаашид Улсын бүртгэлийн хэлтэс гэх/ нь “Бүртгэлийн ангиллыг тогтоох, үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн сангийн улсын бүртгэл хөтлөлтийг хэрэгжүүлэх.” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.



#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулах,
- Хэлтсийн албан хаагчдыг төрийн захиргааны удирдлагаар хангаж, бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд ил тод, чирэгдэлгүй хүргэх,
- Бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, чадавхжуулах.
- Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, холбогдсон үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах,
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, холбогдсон үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах,
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Улсын бүртгэлийн үйлчилгээнд мэдээллийн цахим санг ашиглах,
- Улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах,
- Суманд бүртгэгдсэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийг төв сүлжээнд шууд дамжуулж, мэдээллийн санг бүрдүүлэх,
- Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,



Мөнгөн хөрөнгө	-	185.9	185.9
Авлага	-	19,800.0	19,800.0
Урьдчилж гарсан зардал	-	-	-
Бараа материал	82,497.8	83,717.1	1,219.3
Үндсэн хөрөнгө	245,251.5	219,520.3	(25,731.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>327,749.3</b>	<b>323,223.3</b>	<b>(4,526.0)</b>
Өр төлбөр/урьдчилж орсон орлого	-	185.9	185.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	327,749.3	323,037.4	(4,711.9)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>327,749.3</b>	<b>323,223.3</b>	<b>(4,526.0)</b>

Мөнгөн хөрөнгө данс 185.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ХААН банкин дахь харилцах данс *Иргэний бүртгэлийн үйлчилгээний орлогын 5692290477 дугаар дансанд 2.9 мянган төгрөг, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээний орлогын 5692290488 дугаар дансанд 171.0 мянган төгрөг, хил нэвтрэх эрхийн үнэмлэхийн орлогын 5692290499 дугаар дансанд 12.0 мянган төгрөг/* үлдэгдэлтэй тайлагнагдсанаас шалтгаалсан байна.

Авлага данс 19,800.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь нийт 19,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий 16 ширхэг “dohna” архивын нягтруулсан шүүгээг Сити сейф ХХК-иас он дамжиж буюу 2023 оны 3 дугаар сарын 30-ны дотор худалдаж авахаар 12 дугаар сарын 13-ны өдөр гэрээ байгуулж, төлбөрийг урьдчилан шилжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 83,717.1 мянган төгрөг болж 1,219.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 16,313.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 21,363.7 мянган төгрөгийн бараа материалыг УБЕГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан болон ТӨБЗГ-ын 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А-1/163 дугаар албан бичгийн дагуу 6,500.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн, 29,958.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 430,438.4 мянган төгрөг болж 29,391.0 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А-1/163 дугаар албан бичгийн дагуу бараа материалын данснаас 6,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэсэн болон 673 дугаар тогтоолоор 22,891.0 мянган төгрөгийн цахим үйлчилгээний киоск машин */иж бүрдэл/-*ыг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсантай холбоотой байна.

Өр төлбөр данс 185.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ХААН банкин дахь харилцах дансанд төвлөрүүлсэн орлогыг тайлант оны эцэст төрийн сан дахь 100130012008 дугаар дансанд төвлөрүүлж, төсөвт татан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 323,037.4 мянган төгрөг болж 4,711.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 770,386.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 58,863.0 мянган төгрөгөөр бууруулж / цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 14,027.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 9,045.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,408.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3,546.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 4,670.0 төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 8,733.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,400.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 13,020.0 мянган төгрөгөөр тус тус бууруулснаас шалтгаалсан байна./ 711,523.4 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт дараах байдлаар зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- Эд хогшил, урсгал засварын зардлыг 19,911.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 40,000.0 мянган төгрөгөөр бууруулж,
- Байр ашиглалттай холбоотой зардлыг 818.0 мянган төгрөгөөр бууруулж,
- Хангамж, бараа материалын зардлыг 2,760.2 мянган төгрөгөөр бууруулж,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 294.2 мянган төгрөгөөр бууруулж,
- Бараа, үйлчилгээний бусад зардлыг 222.9 мянган төгрөгөөр бууруулж гэх мэт.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 688,976.4 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 688,976.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 683,850.3 мянган төгрөг буюу 99.3 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 170.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 4,602.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 151.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 145.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 55.5 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 0.6 мянган төгрөгөөр гэх мэт батлагдсан төсвийг нийт **5,126.1** мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	687,660.8	682,535.3	5,125.5	99.3
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,315.6	1,315.0	0.6	99.9
	<b>Нийт</b>	<b>688,976.4</b>	<b>683,850.3</b>	<b>5,126.1</b>	<b>99.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.


### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд УБЕГ-аас аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулах зардалд 12,261.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 11,162.4 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 1,099.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- *Аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгуулийн хэсгийн хороодын итгэмжлэгдсэн ажилтнуудын урамшуулал, НДШ-ийн зардалд 7,104.4 мянган төгрөг,*
- *Тоног төхөөрөмжийн тээврийн зардалд 2,116.0 мянган төгрөг,*
- *Ажилтнуудын томилолтын зардалд 1,062.0 мянган төгрөг,*
- *Шатахууны зардалд 648.0 мянган төгрөг,*
- *Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 175.0 мянган төгрөг,*
- *Бичиг хэргийн зардалд 57.0 мянган төгрөг зэрэг нийт 11,162.4 мянган төгрөг гэх мэт.*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл болон төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 84 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал


Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 798,265.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,982.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүйд гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд УБЕГ-ын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 8/4645 албан бичгээр зөвлөмж өгсөн бөгөөд тус хэлтэс нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс халаалтын зардлын үнийг нэмэгдүүлсэн хэдий ч албан конторын түрээслүүлэгч аймгийн ЗДТГ-тай тохиролцсоноор байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг батлагдсан төсөвтөө багтааж, өр төлбөр үүсгээгүй,



- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг дотоод сүлжээгээр цахим хэлбэрт шилжүүлж, бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг 21.5 хувь буюу 2,162.0 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Дотоод албан томилолтын зардал гаргалгүй ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал гараагүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 669.2 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 3,871.5 мянган төгрөгийн албан шаардлага, 6,703.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бол төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй худалдан авалттай холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд зөрчлийг давтан гаргасан байна. Зөвлөмжийн биелэлт 83.3 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	669.2	1	669.2	100
Албан шаардлага	1	3,871.5	1	3,871.5	100
Зөвлөмж	2	36,720.5	1	6,703.0 <sup>1</sup>	50
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>41,261.2</b>	<b>3</b>	<b>11,243.7</b>	<b>83.3</b>

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 992.7 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

Улсын бүртгэлийн ерөнхий газраас тайлант оны 12 дугаар сард тус хэлтсийн багаж, техник, хэрэгслийн зардлыг өсгөсөн төсвийн зохицуулалт хийж санхүүжилтийг оройтуулснаас худалдан авалтыг төсвийн жилд багтаан гүйцэтгэх боломжгүй байдалд хүрч нийт 19,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий 16 ширхэг “dohna” архивын нягтруулсан шүүгээг Сити сейф ХХК-иас он дамжиж буюу 2023 оны 3 дугаар сарын 30-ны дотор худалдаж авахаар 12 дугаар сарын 13-ны өдөр гэрээ байгуулж, төлбөрийг урьдчилан шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 1,167.9 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгөв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Албан шаардлага

1. Сэлэнгэ ариутгал ХХК-иар 2021 онд гүйцэтгүүлсэн ариутгалын ажлын хөлс 175.2 мянган төгрөгийн өр төлбөрийг өмнөх оны санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант жилийн батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.3 “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, нэгэнт үүссэн өр, авлагыг бүртгэл, тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 992.7 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:” 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасны дагуу тайлант оны санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг иж бүрэн хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

